



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№73 /287/

2022.04.15

НИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД “ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТ”-АД ХАМРАГДЛАА



Батлан хамгаалах яам, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хамтран зохион байгуулж буй Үндэсний аюулгүй байдал, орон нутгийн хамгаалалтыг хангах чиглэлээр онолын мэдлэг, дадлага, ур чадвар олгох “Цэргийн бэлтгэл сургалт” өнөөдөр эхэллээ. “Цэргийн бэлтгэл сургалт”-ын нээлтэд Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцож, оролцогчдод мэндчилгээ

дэвшүүлэн, сургалтын үйл явцад амжилт хүсэж үг хэлсэн юм. Мөн нээлтэд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ж.Батбаясгалан, СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, Нийслэлийн цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт нарын удирдлагууд хүрэлцэн ирсэн юм. Хоёр өдөр үргэлжлэх уг сургалтын үеэр Иргэдийн хурлын

төлөөлөгчид маань Бүх цэргийн их хар сүлдэнд хүндэтгэл үзүүлж, Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд байрлаж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, аюулгүй байдлыг хангахад Төрийн цэргийн байгууллагын оролцоо, Монгол Улсын гадаад бодлого, Батлан хамгаалах бодлогын үндэс, Улсын дайчилгааны тухай ойлголт, орон нутгийн хамгаалалт, төрийн болон албаны тухай хууль, хадгалалт хамгаалалт, мэдээллийн аюулгүй

байдлын тухай болон гамшигослын үеийн шуурхайн удирдлага, зохион байгуулалт зэрэг сэдвийн хүрээнд Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Тагнуулын ерөнхий газрын мэргэжилтнүүдийн сургалтыг сонсоно. Мөн цэргийн бэлтгэл, дадлага сургалтад хамрагдахаас гадна Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн гардан тулааны үзүүлэх тоглолт, ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн хэсэгчилсэн тоглолтыг үзэж сонирхоно.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ХЯНАН ШАЛГАГЧ ХӨДӨӨ ОРОН НУТАГТ АЖИЛЛАЖ БАЙНА



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зэвсэгт хүчний бэлэн байдал, зэвсэглэл цэргийн техникийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, хурандаа Н.Пүрэвдорж, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Цэргийн нэгдсэн сургуулийн Ерөнхий цэргийн тэнхимийн цэргийн сэтгэл зүйн багш, ахлах дэслэгч Г.Амгалан нарын ажлын хэсэг хөдөө орон нутгийн анги салбаруудад энэ сарын 13-15-ны хооронд ажиллаж байна. Тодруулбал Улаанбаатар- Дархан чиглэлийн авто замыг сэргээн сайжруулах ажилд оролцож буй Барилга Инженерийн цэргийн удирдах газрын харьяа Зэвсэгт хүчний 110, 341 дүгээр анги болон Хуурай замын цэргийн командлалын харьяа Зэвсэгт хүчний 186, 234 дүгээр анги, Тусгай хүчний цэргийн командлалын харьяа Зэвсэгт хүчний 330 дугаар анги, Агаарын цэргийн командлалын харьяа Зэвсэгт хүчний

065 дугаар ангийн 322 дугаар салбарт ажиллаж байна. Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч анги салбарын барилга байгууламж, цэргийн байр, хугацаат цэргийн алба хаагчдын амьдарч буй орчин нөхцөлтэй танилцаж тэдний санал сэтгэгдлийг сонсож анги салбаруудын бие бүрэлдэхүүнтэй уулзаж батлан хамгаалах бодлого, зорилт, салбарын хэмжээнд хийж хэрэгжүүлсэн, цаашид хийгдэх онцлох ажлуудын талаар мэдээллийг өгч ажиллаж байна.

Түүнчлэн ажлын хэсгийн гишүүд Батлан хамгаалах бодлог үйл ажиллагааг сурталчлах уулзалтыг зохион байгуулж анги салбарын бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагчдыг оролцуулан цэргийн сэтгэл зүйн зөвлөгөө өгч, ёс зүй, харилцаа хандлагын талаар сургалт явуулах юм. Мөн анги салбаруудын зэвсэг, галт хэрэглэлийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцаж сум галт хэрэглэлийн аюулгүй байдалд үзлэг хийж байна.

Дэслэгч Н.ЭНХТОГТОХ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,319 /69.8%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,174,350 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,031,374 31,7% 113,435 /3,5%/
НИЙТ БАТЛАГДСАН 8431 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 5	ЭДГЭРСЭН 8306

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 478,183,956
Эдгэрсэн Нийт: 412,796,781
Нас барсан Нийт: 6,133,665

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
Өдөр	Шөнө
☀️ 6	🌙 -11
ӨМНӨД СУДАН	
Өдөр	Шөнө
☀️ 35	🌙 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,130.00	3,170.0
EUR 🇪🇺	3,48.0	3,540.0
CNY 🇨🇳	502.00	507.00
RUB 🇷🇺	35.00	36.30
JPY 🇯🇵	26.30	27.50
KRW 🇰🇷	2.60	2.67

ЗУРХАЙ

2022.04.15 БААСАН ГАРАГ БИЛГИЙН ТООЛЛЫН 14

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал арвидна
Наран ургах, шингэх:
06.03-19.41
Барилдлага:
Үл тохирох
Шүтэн барилдлага:
Сэрэхүй
Суудал: Мод

Энэ өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогосод хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

МЕНИНГИТ ӨВЧИН

МЕНИНГИТ ӨВЧИН ТЭМЦЭГ

- СЭГЭТ ӨВЧӨР ХАЛДВАР
- СЭВЭГНИЙ
- ИЭРЧ
- СЭЛЭЛ
- ХӨРЛӨГӨЛ, ДЭЛХИЙ СЭРГЭТ
- ЦЭРЭМГИЙН ӨВЧИН
- ЦЭРЭМГИЙН ӨВЧИН
- ТӨТӨХ ҮС МӨӨР ХҮҮСЭН ӨВЧИН
- КОЛОНОСКОПИЙН ӨВЧИН

СРЬЛЧИЛАН СЭРГҮҮЛЭХ АРТЭСӨ

- НАРЫН КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ
- КОЛОНОСКОПИЙН ҮНДЭСНИЙ

05 НАСНЫ ХҮҮХДҮД ҮГ ХАЛДВАРЫН ӨВЧӨНД ТӨХИӨЛДӨЛД МАШ ХУРДАН ХИЦЭГДЭГ ТҮЛ ЦАГ АЛДАЛ ҮЙ ЭМНЭЛЭГТ ХАНДАГАЙ!

